

### Эзжийн захидал

Хичээлдээ тааруухан, сэтгэлийн тэнхээ сул дорой хүүхэдтэй нэгэн ээж байжээ. Ээж нь цаг ямагт хүүдээ амжилт гаргаж чадна гэсэн итгэлийг төрүүлдэг байлаа. Хүү нь ч гэсэн ээжийнхээ итгэлийг алдахгүй тулд хичээдэг байв.

Хүүгээ дайнд явахын өмнө ээж нь хүү дээрээ ирээд олон хумуусийн юу гэхийг тоохгүйгээр «Миний хүү дайнд хамгийн шилдэг нисгэгч болно» гэж чангаар хэлжээ. Гурвал жил хагасын турш үргэлжилсэн дайнд хүү нь эрэлхэгээр тулалджээ. Түүнд хүч зориг өгч байсан зүйл бол түүний ээжийн тасралтгүй илгээдэг байсан захидалууд байлаа. «Миний баахархал болсон хүү минь» гэж эхэлсэн ээжийнх нь захидалууд цаг өнгөрөх тусам агуулга нь багасаж, хурдан татлан бичсэн юм шиг харагдах болсон тул эрүүл байна гэж бичдэг ээжийнхээ үгэнд хүү нь эргэлзэдэг байлаа.

Дайн дуусахын үед нэгэн захидал хүлээн авлаа. Захидалд «Хайрт хүү минь одоо баттай зогс! Хүчирхэг бол!» гэсэн байв. Энэ богинохон захидал яагаад ч юм хүүгийн сэтгэлд хоногшин үлджээ. Дайн дуусаж хүү нь Францын элчин сайдын газар ажиллахаар томилогдов. Хүү энэ баярт мэдээг юуны өмнө зэждээ дуулгахаар очсон боловч ээж нь аль хэдийн нас барсан байлаа. Ээж нь гурван жилийн өмнө өөрийн үхэхийг тааварлан мэдээд хүүгээ хүч тэнхээтэй байлгах гэж нэгэн арга сийлжээ.

Энэ нь бурхан болохынхoo өмнө долоо хоногийн турш чичигнэж салганасан гараараа 25 захидал бичиж, түүнийгээ өөрийн найзад өгч, хүүдээ нэг нэгээр нь явуулж байхыг хүссэн байжээ.

#### **1. Эхийн өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлээрэй | 2 оноо |**

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....

#### **2. Эхээс зоригжуулж буй өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэр олж бичээрэй. | 2 оноо |**

- .....  
.....  
.....

#### **3. “Хичээлдээ тааруухан, сэтгэлийн тэнхээ **сул дорой** хүүхэдтэй нэгэн ээж байжээ.” гэсэн өгүүлбэрт байгаа тодруулсан үг өгүүлбэрт ямар утгаар орсон байна вэ? | 2 оноо |**

- .....  
.....

#### **4. “ Манай ангийн охидууд волейболын тэмцээнд түрүүллээ.” гэсэн өгүүлбэрийг зөв засан найруулаарай. | 2 оноо |**

- .....  
.....

#### **5. Зөвлөлийн тэмдэг “и” болохгүй дүрэмтэй үг 2-ыг бичээрэй. | 2 оноо |**

**6. Хуульч Сандаг “Салхинд хийссэн хамхуулын хэлсэн үг” шүлгийг гүйцээж бичээрэй.\ 5 оноо \**


Үрийн сайнаар ургаж .....  
Үндэсний муугаар ховхорлоо.

Төрсөн газар төхөмд сөн .....  
Төлдрийн салхинд гарсан сан.

Нүүхийг салхи мэднэ .....  
Буухыг бут мэднэ

Энэхэн бие минь

**7. “~~Ж-ЭМЧИ~~” дараах үгийг тийн ялгал, биед хамаатуулах нөхцөл олон тооны нөхцөлөөр хувилгаарай. \ 5 оноо \**



## Учлах гэдэг ухааных

Долоо хоногийн эхний өдөр дунд сургуулийн багш сурагчдадаа нэгэн туршилтад оролцохыг хүсч байгаа эсэхийг нь асуулаа. Мэдээж энэ нь амьдралын гэсэн тодотголтой байсан нь хүүхдүүдийн сонирхлыг ихэд татсан учраас тэд ч дуртай нь аргагүй зөвшөөрөв.

Багш хүүхэд бурийг маргааш 5 кг төмс, 1 гялгар уут авчрахыг даалгавар болгоход хүүхдүүд чухам яах гээд байгааг нь огт ойлгоогүй ч даалгаврыг биелүүлжээ. Багш анги руу ороод өөр рүү нь хариулт нэхсэн нүдээр харах сурагчдадаа “За одоо та нар өнөөдрийг хүртэл үзэн ядаж явдаг хүмүүсийнхээ нэрийг нэг, нэг төмсөн дээр бичээд тор руугаа хий” гэж хэлэв. Ийн хэлээд удаа ч үгүй байтал зарим хүүхдийн тортонд хэдхэн төмс орсон байхад заримынх нь бүр дүүрэн болсон харагдана. Ингээд бүх хүүхдүүд тортонд төмсөө хийж дууссаны дараа багш “Одоо та нар наад тэмстэй тороо хaa явсан газраа авч яв. Унтахдаа орныхоо хажууд тавь, автобусанд суухдаа, тэр ч байтугай хичээлдээ ирэхдээ хүртэл авч ирээрэй” гэж хэлэв.

Энэ өдрөөс хойш долоо хоног өнгөрөв. Ингээд тогтсон хугацаа болж багшийг ангид орж ирэв үү үгүй юу л “Багш аа, ийм хүнд ачааг үргэлж барьж явах надад хэцүү байна. Багш аа, төмс ялзарч эхэлсэн. Би залхаж ядарч байна” гэх зэрэг үргэлжилсэн их гомдол тавьжээ.

Гэтэл багш нь инээмсэглэн байж “Аливаа хүнийг учлахгүй байх нь тэднийг бус өөрийгөө шийтгэж байдаг гэдгийг та нар ойлгосон гэж бодож байна. Ингэснээрээ бид өөртөө л хүнд ачааг үүрдэг. Ер нь эцэст нь хэлэхэд, бусдыг училна гэдэг бол чиний өөрөө өөртөө хийж байгаа сайн зүйл юм” гэж хэлжээ.

**1. Эхийн өрнөсөн үйл явдлыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлээрэй | 2 оноо |**

- 1.....
- 2.....
- 3.....
- 4.....

**2. Эхээс гомдоллож буй өнгө аясыг илэрхийлсэн өгүүлбэр олж бичээрэй. | 2 оноо |**

.....

.....

**3.“Энэ өдрөөс хойш долоо хоног өнгөрөв. Ингээд тогтсон хугацаа болж багшийг ангид орж ирэв үү үгүй юу л” гэсэн өгүүлбэрт байгаа тодруулсан үг өгүүлбэрт ямар утгаар орсон байна вэ? | 2 оноо |**

.....

.....

**4.“ Манай ангийн охицууд волейболын тэмцээнд түрүүллээ.” гэсэн өгүүлбэрийг зөв засан найруулж бичээрэй. | 2 оноо |**

.....

.....

**5. Зөвлөлийн тэмдэг “и” болохгүй дүрэмтэй үг 2-ыг бичээрэй. | 2 оноо |**

---

---

**6. Хуульч Сандаг “Салхинд хийссэн хамхуулын хэлсэн үг” шүлгийг гүйцээж бичээрэй. | 5 оноо |**

Үрийн сайнаар ургаж .....  
Үндэсний муугаар овхорлоо. ....  
Төрсөн газар төхөмд сөн .....  
Төлдрийн салхинд гарсан сан. ....  
Нүүхийг салхи мэднэ .....  
Буухыг бут мэднэ .....  
Энэхэн бие минь .....

**7. “” дараах үгийг тийн ялгал, биед хамаатуулах нөхцөл олон тооны нөхцөлөөр хувилгаарай. | 5 оноо |**

